

ДУНДГОВЬ АЙМГИЙН ИТХ, ЗДТГ-ЫН 2019 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Аймгийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын 8 агентлагийн албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийн гишүүд нийт 23 хүнд Албан тушаалын тодорхойлолт боловсруулалтыг сайжруулах талаар сургалт, мэдээлэл хийж, сургалтаар өгсөн чиглэлийн дагуу 10 сарын 10-ны дотор Төрийн албаны салбар зөвлөлд ирүүлэх чиглэл өглөө. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалын ангилал зэрэглэл өөрчлөгдсөнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга нарын ангилал, зэрэглэлийг шинэчилсэн шийдвэр гаргууллаа. Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэл ажлын хүрээнд аймгийн ЗДТГ-ын архивын аюулгүй байдлыг ханган дохиололын системийг суурилуулж, цахим архивын зөөврийн төхөөрөмжийг байрлуулах цахим архивын санг бий болгож, мэдээллийн технологи, цахим архивын талаар сургалтын танилцуулга, гарын авлагыг бэлтгэн гаргалаа.

Аймгийн ЗДТГ-ын дарга Ц.Эрдэнэсүрэн аймгийн Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төвд оёдол эсгүүрийн чиглэлээр зөвлөхөөр ирсэн Герман улсын сайн дурын ажилтан, ахмад багш Зонтаг Аугенштайн болон Гуян хотын төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Уулзалтанд аймгийн МСҮТ-ийн удирдлага, оёдлын ангийн оюутнууд оролцлоо.

Зүүн хойд Азийн захиргааны холбоо NEAR байгууллагаас ЕБС-ын сурагчдын дунд зохион байгуулж байгаа 7 дах удаагийн постер, зургийн уралдааны удирдамжийг цахим хуудсанд байршуулан аймгийн ЕБС-уудад албан тоотоор хүргүүлээ.

Монгол улс, БНХАУ-тай дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн баярыг тохиолдуулан ӨМӨЗО-ны Баяннуур хотын Улаат өмнө хошуунд зохион байгуулагдах 23 дахь удаагийн бөхийн холбооны тэмцээнд 5 хүн оролцлоо.

“Хурд” хамтлагийн санаачлан МУ-ын Засгийн газрын ивээл дор зохион байгуулагдаж буй “ХАЙРТАЙ” аян, Дундговь Түншлэл-2019, Монгол улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн арга хэмжээний талаарх мэдээллийн сурталчилгааны эхийг бэлтгэн Мандалговь хотын 3 самбар, цахим хуудас, аймгийн ЗДТГ-ын албан ёсны пэйж хуудас зэрэг мэдээллийн хэрэгсэлд байршуулан сурталчиллаа.

“Хурд” хамтлагийн санаачлан МУ-ын Засгийн газрын ивээл дор зохион байгуулагдаж буй “ХАЙРТАЙ” аян 2019.09.16-17-ны өдрүүдэд Дундговь аймагт үргэлжиллээ

ЗГХЭГ, Удирдлагын академиас “Төрийн албан хаагчийн сургалтын бодлого, тогтолцоо, Академиас хэрэгжүүлэх сургалтын үйл ажиллагааны шинэчлэл” сэдэвт цахим хурал зохион байгуулж хуралд аймгийн ЗДТГ-ын дарга, хэлтсийн дарга нар, хүний нөөцийн ахлах мэргэжилтэн нийт 7 албан хаагч оролцож “Төрийн албан хаагчийн сургалтын бодлого, тогтолцоо, Академиас хэрэгжүүлэх сургалтын үйл ажиллагааны шинэчлэл” сургалтыг хийж, хэлэлцүүлэг явууллаа.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу Дундговь аймгийн хүний нөөцийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд сумдаас судалгаа авах ажлыг зохион байгуулж байна.

Монгол улс, БНХАУ-тай дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд баярын хурал, гадаад хамтын ажиллагааны өдөрлөгийг БНХАУ-аас Замын үүдэд суугаа ерөнхий консулын газартай хамтран зохион байгууллаа. ЗДТГ, БНХАУ-аас Замын-Үүд суманд суугаа Ерөнхий консулын газартай хамтран аймгийн ЕБС, МСҮТөвийн сурагч, хүүхдүүдийн дунд “Монгол- Хятадын найрсаг харилцаа” гар зураг, “Миний мэдэх Хятад Улс” сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг зохион байгуулж БНХАУ-аас Замын-Үүд суманд суугаа Ерөнхий консулын газраас уралдаанд амжилттай оролцсон 2 сургууль, 90 хүүхдэд 16 сая төгрөгийн

шагнал, шилдэг тэргүүний болон зорилтот бүлгийн 40 хүүхдэд 20 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж гардуулж, 8-р цэцэрлэгийн тоглоомын санхүүжилтын асуудлыг шийдвэрлэж өглөө.

Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн утган зохион байгуулсан бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргаж, аймгийн ЗДТГ-ын архив, бичиг хэргийн ажилтнуудын техник тоног төхөөрөмжийг паспортжуулан холбогдох хөтөлгөөг хийж, цахилгааны гэнэтийн саатлаас хамгаалсан тог баригчуудыг холбон, аймгийн ЗДТГ-ын цахим нөөцийн дискийг үүсгэж, холбогдох цахим мэдээллүүдийг архивлан архивын ажилтанд хүлээлгэн өгч, заавар зөвлөмжийг өглөө.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Өглөг, авлага

№	Өглөг, авлага	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Үлдэгдэл
1	Өглөг	389,695,4	95,046,9	49,327,6	435,414,7
2	Авлага	496,739,1	10,584,1	26,246,9	481,076,4
Нийт		886,434,5	105,631,0	75,574,5	946,491,1

Төсвийн гүйцэтгэл

№	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1	35,572,270,6	34,879,841,9	98,1%

Орлого

№	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1	14,343,290,9	16,017,820,3	111,7%

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцон аймгийн ЗДТГ-ын даргаар хянаууллаа. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Ахмад настан-Хэрэглэгч” өдөрлөгийн удирдамжийг боловсруулан сумдад хүргүүлж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөршил, Гурвансайхан, Дэлгэрцогт, Дэрэн, Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг сумдад “Хууль тогтоомж сурталчлах өдөрлөг”-ийг зохион байгуулав. Уг өдөрлөг нь Иргэн бүрт эрх зүйн боловсрол олгох зорилготойгоор иргэд хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, туслалцааг 181 иргэнд үзүүлж, эрх зүйн сургалтад 644 насанд хүрэгчид, 640 ЕБС-ийн ахлах ангийн сурагчид нийт 1284 хүн тус тус хамрагдлаа. Сум тус бүрт бэлтгэгдсэн 4 эрх зүйн хөтөч нэг бүртэй гэрээ байгуулан “Эрх зүйн хөтөчийн ажиллах журам”-ыг сургалтын үеэр иргэдэд нь танилцуулан, эрх зүйн хөтөчүүдийн үйл ажиллагааг эхлүүллээ. Сумдын эрх зүйн хөтөч нарын үйл ажиллагааг идэвхжүүлж, зохион байгуулсан шилдэг үйл ажиллагааг “Дундговь Эрх зүйн хөтөч” группээр сайн туршлагуудыг түгээн дэлгэрүүлж нийтлэв. Захиргааны хэм хэмжээний актын 24 дүгээр эмхэтгэлд аймгийн ИТХ 2019 оны 7 сарын 1-ний өдрийн 6 дугаар тогтоолоор “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилал, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах устгах булшлах, зардлын нэгж тариф”, мөн 2019 оны 5 дугаар тогтоолоор “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам”, Сайхан-овоо сумын ИТХ-ын 2019 оны 4 дүгээр тогтоолоор “Тус сумын нутаг дэвсгэрт мөрдөх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ”, Дэрэн сумын ИТХ-ын 2019 оны 1 дүгээр тогтоолоор “Тус сумын нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргын хамтарсан 2019 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн А/43, А/69 тушаал, захирамжаар “Дундговь аймгийн Сайнцагаан сумын агаарын чанарыг сайжруулах бүс, уг бүсэд мөрдөх журам”-ийг баталсан эрх зүйн актууд нийтлэгдсэн байна. Цагдаагийн газрын хэсгийн цагдаа нарын цугларалтыг зохион байгуулж, “Цагдаагийн хүрээний дүрэм”, “Цагдаагийн эрүүл

харуулын дүрэм"-ээр сургалт хийсэн. Прокурорын зөвлөгөөнийг зохион байгуулж нийт мөрдөгч нарын шийдвэрлэх хэргийг хэлэлцэж баталсан. "Хүүхэд хамгааллын дэмжих жил"-ийн хүрээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран "Гэр бүл, хүүхдийн хөгжил хамгаалал-2" аяныг Баянжаргалан, Говь-Угтаал, Цагаандэлгэр суманд 9 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус аяны хүрээнд 5-9 дүгээр ангийн 330 сурагчдад "Цахим орчны хэрэглээ", "Хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр сургалт явуулж мэдээлэл өгч, гэр бүлийн хүчирхийллийн талаар 7 хүнтэй биечлэн уулзаж зөвлөгөө, тусламжийн хуудас өгч ажилласан байна.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Хөдөлмөр халамж үйлчилгээний газар: Орон нутгийн онцлогын 150 сая төгрөгийн төслийг боловсруулж ХХҮЕГазарт хүргүүлсэн. Улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалттай ажлыг хийж гүйцэтгэхээр тендэрт шалгарч үйл ажиллагаа нь эхэлсэн 11 аж ахуйн нэгжид явцын хяналт хийж түр ажлын байранд зуучлуулсан 46 иргэн ажлын байртай танилцлаа. Луус суманд ахмад настан болон ХБИргэдэд ортепедийн тусгай хэрэгсэл нийлүүлсэн Грийн мэпл Канстракшн ХХК санхүүжилтэд 12,4 сая төгрөгийн санхүүжилт олгосон. "Иргэн төвтэй төрийн үйлчилгээ"-ний жилийн ажлын хүрээнд Сайхан-Овоо, Дэлгэрхангай сумын ЗДТГ-тай хамтран "Төрийн үйлчилгээ"-г иргэдэд хүргэх өдөрлөг арга хэмжээг зохион байгуулж 150 иргэнд мэдээлэл хүргэн, иргэдийн санал хүсэлтийг газар дээр нь шийдвэрлэн ажиллалаа. Тус өдөрлөг арга хэмжээний үеэр "Говийн бүсийн арга зүйн төв"-тэй хамтран Сайхан-Овоо, Дэлгэрхангай сумын зорилтот бүлгийн 100 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран ажилладаг "Грийн Мэпл констракшн" ХХК-аас ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд ортопед, тусгай хэрэгслийг үнэ төлбөргүй олгох үйлчилгээ үзүүлжээ. Дэлгэрхангай, Сайхан-Овоо сумын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 31 өрхийн хувийн хэргийг цахимд шилжүүлэн, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг, жижиг зээлд хамрагдсан иргэдийн үйл ажиллагаа, ажилд зуучлагдсан иргэд, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлж буй хүнсний дэлгүүрт хяналт хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. О-3 настай хүүхэд асарч буй эхчүүдэд олгож буй "Цалинтай эх"-н 9 дүгээр сарын тэтгэмжид 107,6 сая төгрөгийн санхүүжилтыг арилжааны банкуудаар хуваарилан олголоо.

Эрүүл мэндийн газар: Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн холбооноос аймгийн төвийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийг чадавхижуулах 2 хоногийн сургалтыг 24 хүнд зохион байгууллаа.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвөөс эхийн эндэгдлийн тохиолдлыг танилцуулж эхийн эндэгдэл давтагдан гарахаас сэргийлэх зорилгоор "Манас таталтын урьдлын хүнд хэлбэр" сэдвээр цахимаар сургалт хийж удирдлагууд зөвлөх эмч нарыг хамрууллаа. "Гемодиализын техник технологи ба эмчилгээний дэвшил" чуулганд тоног төхөөрөмжийн техникч, гемодиализ хариуцсан эмч сувилагчийг оролцууллаа.

Эрүүл мэндийн газраас Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх аяны хүрээнд аймгийн Замын цагдаагийн тасагтай хамтран хөдөө, орон нутгийн замд осол аваар гарч болохуйц хар цэгийг тодорхойлон төмөр цагдааг байрлууллаа.

Монголын Сувилагчдын Нийгэмлэгээс уламжлал болгон зохион байгуулсан Зүүн бүсийн сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн спортын 4 төрөлт тэмцээнд баг тамирчид Гар бөмбөг тэргүүн байр, Одон бөмбөг тэргүүн байр, Сагсан бөмбөг 3-р байр, Шатрын тэмцээнд 4-р байр багийн амжилтаар Дэд байр эзэлж амжилттай оролцлоо.

Өмнөговь аймагт зохион байгуулагдсан "Эмнэлгийн эрүүл ахуй, халдварын сэргийлэлт ба хяналт Симпозиум"-д халдвар хяналтын багийн 11 эмч мэргэжилтэн оролцлоо. Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, иргэд үйлчлүүлэгчдийн дунд нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн гаж нөлөө, нянгийн тэсвэржилтээс сэргийлэх, антибиотик эмийн зохистой хэрэглээний мэдлэг олгох, дадал хандлага эзэмшүүлэх сурталчилан таниулах зорилгоор "НЯНГИЙН ТЭСВЭРЖИЛТ БА АНТИБИОТИК ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ" сэдвээр нээлттэй мэдээллийн өдөрлөг зохион байгуулж 160 гаруй иргэд, үйлчлүүлэгч, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан ба

антибиотикийн зохистой хэрэглээний талаар үйлчлүүлэгч нарт 85 ширхэг гарын авлага бэлтгэн тарааж зөвлөмж өгсөн.

Дэлхийн эрүүл мэндийн 72 дугаар чуулганаар жил бүрийн 9 дүгээр сарын 17-ны өдрийг “ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДЭЛХИЙН ӨДӨР”-өөр үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, олон нийтийн оролцоо, мэдлэгийг нэмэгдүүлэх, дэлхий нийтийн үйл ажиллагаа, эв нэгдлийг идэвхижүүлэх, ойлголтыг сайжруулахад анхаарал хандуулан. “Дэлхийн эрүүл мэндийн тэргүүлэх чиглэл бол Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал” сэдвийн дор 9 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын төлөө дуу хоолойгоо нэгтгэцгээ” уриатайгаар тэмдэглэн өнгөрүүлж байна. Байгууллагын эмч, эмнэлгийн ажиллагсад чанарын үзүүлэлт, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдлээс сэргийлэх үйл ажиллагааны “Сайн туршлага” хэрэгжүүлж буй туршлагаа ярилцав. Мөн Чанарын өдөрлөгийг зохион байгуулж Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас гаргасан үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаархи 10 баримт, стратеги, зорилтуудыг танилцуулж, антибиотекийн зохистой хэрэглээ, гарын эрүүл ахуй сэдвүүдээр сургалт явуулж 165 иргэд, үйлчлүүлэгч, эмч, эмнэлгийн ажиллагсдыг хамрууллаа.

Хүүхдийн тасгийн хамт олон өөрсдийн хөрөнгө, хүчээр үйлчлүүлэгч хүүхдүүддээ зориулж тоглоомын өрөөгөө тохижууллаа. Хананы зураг, тоглоомоор баяжуулж ээлтэй орчинг бүрдүүлэв. Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс явуулсан “ХДХВ Тэмбүүгийн халдварын тархалт” семенарт Нэгдсэн эмнэлгийн Халдвартын их мч, лаборант нар оролцоо. Адаацаг Цагаандэлгэр суманд ус намгийн шувуудын ажиглалт тооллогоор ажиллан, Хулд, Эрдэнэдалай, Дэрэн, Цагаандэлгэр сумдын боом өвчний голомтот газруудаас хяналтын шинжилгээнд сорьц дээжиллээ. Сахуу татрангийн эсрэг вакциныг зорилтот насны 512 хүүхдүүдэд хийлээ. Томуу томуу төст өвчний вакцинд хамрагдах зорилтот насны хүмүүсийн судалгааг сум өрхийн эрүүл мэндийн төвүүдээс авч нэгтгэн Халдварт өвчин судлалын үндэсний төвд хүргүүлээ. Хулд, Эрдэнэдалай, Дэрэн, Цагаандэлгэр сумдын боом өвчний голомтот газруудаас хяналтын шинжилгээнд 30 сорьц дээжилж нян судлалын лабораторит хүлээлгэн өгч шинжилгээ хийгдэж байна.

“Эрүүл шүд эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийгмийн эрүүл мэндийн хэлтсээс бага насны хүүхдийн амны хөндийн эрүүл мэнд, шүд угаах талаар 4,5,6-р цэцэрлэгийн 4-5 насны нийт 265 хүүхдэд сургалт хийлээ.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 90 дүгээр зарлигаар 2019-2020 оныг “Хүүхэд хамгааллыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан “Гэр бүл, хүүхдийн хөгжил хамгаалал-2” аяны хүрээнд “Хүүхэд залуучуудын эрүүл мэндийг дэмжих дэмжье” өдөрлөгийг Цагаандэлгэр, Баянжаргалан, Говь-Угтаал сумдад Гэр бүл хүүхэд залуучуудын газартай хамтран зохион байгууллаа. Өсвөр үеийн эрүүл мэндийн талаар лавлах мэдээллийн багц бэлтгэн, өсвөр үеийнхэн болон тэдний эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт сургалт, сурталчилгаа зохион байгуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эмчлэн эрүүлжүүлэх, зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн асуудлаар боловсрол, нийгмийн хамгаалал болон бусад салбарынхантай хамтран ажиллаж байна. Тус өдөрлөгийн хүрээнд 5-9-р ангийн 171 сурагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, Нөхөн үржихүйн боловсрол олгох болон бэлгийн ариун цэвэр, гэр бүл төлөвлөлтийн сургалт, Цахим орчны хэрэглээ, хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хорт зуршил архи тамхины хор уршгийн талаарх сургалтыг 171 хүүхдэд зохион байгууллаа.

Боловсрол, спорт, соёл урлагийн чиглэлээр: Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор “Хурд” хамтлагийн санаачилгаар хэрэгжиж буй “*Хайртай*” төслийн үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран амжилттай зохион байгуулсан. АНУ-ын ЭСЯ-ын санхүүжилтээр зохион байгуулж буй Access хөтөлбөрийн 2 дахь жилийн нээлтийг зохион байгууллаа. БСУГ-т ажиллаж буй ЭТК-ын сайн дурын ажилтан Сэмтэй хамтран Сайнцагаан сумын СӨБ-ын багш ажилтнуудад англи хэлний анхан шатны сургалтыг эхлүүлж 25 багш ажилтан хамрагдлаа. Сургалт 20 долоо хоног бөгөөд амжилттай суралцагчдад сертификат олгох юм.

2019-2020 хичээлийн жилд Нэгдүгээр анги дааж ажиллаж буй 33 бага ангийн багшид 2 өдрийн сургалт зохион байгуулж ажиллалаа. 9-р сарын 12-ны байдлаар “Олуулаа уншья-Номтой нөхөрлөө” аяны хүрээнд Хүүхдийн уншлагын танхимд шинээр 4 анги бүртгүүлсэн.

Шинэ уншигч 152, насны ангилалаар 1-4 ангийн сурагч 83, 5-6 ангийн сурагч 68, хүйсээр ангилвал 87 эмэгтэй, 55 эрэгтэй, ачаалал 438, олгосон материал 864 байна. Уншлагын их танхимд шинэ уншигч 36, 173 ном зохиол 168 тогтмол хэвлэл сонин сэтгүүл судлан үйлчлүүлсэн байна. VIII-р богд ЖАВЗАНДАМБА хутагтын мэлмий гийсний 150жилийн ойд зориулан бурхан шашны холбогдолтой 57 номоор сэдэвчилсэн үзэсгэлэнг гаргаж байна.

Говь-угтаал суманд зохион байгуулагдсан “Мандалын хурд Уяачдын уралдаанд” тус театрын 3 багш Циркийн дугуйлангийн 5 сурагч, Уртын дууны дугуйлангийн 2 сурагч тоглолтоо өргөн барьлаа. Энх тайвны корпусын зүүн бүс хариуцсан менежерүүд Дундговь аймагт ажиллаж буй сайн дурын ажилтнуудтай хамтран ажиллах төлөвлөгөөний талаар уулзалт ярилцлага зохион байгуулав.

НҮБ-ын олон улсын хүүхдийн сангийн ажилтнуудтай хамтран ГИЦС, Адаацаг сумын сургуулийн 6 охиныг сонгож эрүүл ахуйн гар утасны апплекишны талаар ярилцлага хийлээ. Цэцэрлэгийн багш нарын англи хэлний сургалтыг 25 хүнд зохион байгуулж ажиллаж байна.

Монгол улсын их сургуулийн түүхийн тэнхимийн багш Ж.Гэрэлбадрах, Х.Болдбаатар нар түүхийн судалгааны сүүлийн үеийн байдал сэдвээр түүх нийгмийн ухааны багш нарт мэдээлэл зөвлөгөө өглөө.

“Мөнгөн утас” хамтлагийн 40 жилийн ойн тоглолтын 344 билетийг албан байгууллагуудад хуваарилан өгч, үзэгчдийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан. Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас “Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж байгаатай холбогдуулан холбогдох материалуудыг бэлтгэн, мэдээллээр хангасан.

Хятад Монголын найрамдалт харилцааны 70 жилийн ойн хүрээнд Гар зураг, Эссэ бичлэгийн уралдааны материалуудыг хүлээн авч шалгаруулж, шагналыг гардуулах ажлыг зохион байгуулж шалгарсан материалуудаар үзэсгэлэн гаргалаа.. БСУГ-ын гадаад хэлний мэргэжилтэн Наранбум, сайн дурын ажилтан Алекс, Сэм нар Англи хэлний багш нарын олон улсын 13-р бага хуралд илтгэл тавьж оролцлоо. 2019 оны Шилдэг багш нарын 23 материалыг дүгнэн НБХ-т үнэлгээ дүгнэлтийн хамт хүргүүлжээ.

СӨБ-ийн байгууллагад 22 цэцэрлэгийн 98 бүлэг хичээллэж 3068 хүүхэд хичээллэж 422 ажилтан албан хаагчдаас 204 үндсэн болон туслах багш ажиллаж байна. Хувилбарт сургалтаар 18 бүлгийн 298 хүүхэд сургах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

ЕБС-д 19 сургуулийн 8434 хүүхэд 337 бүлэгт хичээллэж 964 ажилтан албан хаагчаас 520 үндсэн багш 18 дотуур байранд 957 хүүхэдтэй, 15 насан туршийн нэгжид 15 багш, 71 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж байна.

Боловсрол, соёл, урлагийн байгууллагуудын Нээлттэй мэдээллийн өдөрлөг зохион байгуулж ажиллалаа. Насан туршийн боловсролын төвийн нээлтийн үйл ажиллагаа боллоо. Музейн байгууллага үүсч хөгжсөний түүхт 70 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн Баримтат киноны нээлт, Түүхэн гэрэл зургийн үзэсгэлэн, Эрдэм шинжилгээний хуралд түүх угсаатны зүйн хүрээлэнгийн захирал академич Г.Чулуун, МУБИС-ийн багш Ж.Гэрэлбадрах, МУБИС-ийн багш Ч.Болдбаатар, Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат, Монголын бурхан шашны төв Гандантэгчлэн хийдийн дэргэдэх эрдэм соёлын хүрээлэнгийн Амгалан, Монголын үндэсний музейн ажилчид, Палеонтологийн хүрээлэнгийн эрдэмтэн Доктор Майнбаяр нар оролцлоо. Адаацаг сумын уугуул Варшав хотын их сургуулийн Монгол судлалын тэнхимийн багш Рагчаагийн Бямбаа “Монгол төвд судлал”, “Эртний шаазан эдлэл”-ийн сонирхолтой түүхэн цуврал 12 ширхэг ном хандивлалаа..

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Хээлтүүлэгч малд Бруцеллёз өвчний тандалт шинжилгээ хийх удирдамж боловсруулан батлуулж, шаардагдах хэрэглэгдэхүүн, урвалж, шил савыг нийлүүлэгч компаниас хүлээн авч сумдад хуваарилан олгож байна. Мал эмнэлгийн лабораторийг магадлан итгэмжлүүлэх ажлын хүрээнд Чанарын гарын авлага, шаардагдах материалуудыг боловсруулах, бэлтгэх ажил хийлээ.

Шүлхийн дархлаажуулалт хийсэн баримт материалыг 13 сумын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдээс хүлээн авч, хянаж, баримт бүрдүүлсэн. Шүлхийн халдвар илрүүлэх зорилгоор хээрийн нөхцөлд ашиглах зориулалттай урвалж, багажийг туршиж судлав.

Тэмээний вирусын гаралтай өвчний тандалт, шинжилгээ, судалгааг Америкийн нэгдсэн улсын Канзасийн их сургуулийн Юүргэнээр ахлуулсан судлаачдын баг Өлзийт сумын Буянт багт 3 хоногийн хугацаанд 100 толгой ботгоноос цусны болон хамрын арчдасын дээж авч газар дээр нь үүсгэгчийг илрүүлэх "Бодит цагийн- Полимеразийн гинжин урвалыг МЭЛ-ын шинжлэгч эмч нартай хамтран гүйцэтгэв. Мөн халдвар илрүүлэх MERS-CoV буюу дундад азийн тэмээний амьсгалын эрхтэн тогтолцооны вирусын хам шинжийн Коронавирус илрүүлэх урвал, арга зүйг туршихад судалгаагаар дээрх 2 өвчний вирусын халдвар илрээгүй нь таамаглаж байсан үр дүн байв. Судалгааны ажлыг МЭ-ийн явуулын лабораторийг ашиглан гүйцэтгэв. Лаборатор нь хээрийн ямар ч нөхцөлд ашиглах боломжтой молекулийн түвшний шинжилгээ хийхэд хэвийн ажиллаж байлаа. Уг сургуультай хамтийн ажиллагааны хүрээнд 10 төрлийн үүсгэгчийг молекул биологийн аргаар илрүүлэх урвалж, бодисыг МЭЛ-т авсан нь гадаад хамтын ажиллагааны хүрээнд үнэтэй ажил болов. Бруцеллёзын вакцинжуулалтын явцын мэдээгээр бруцеллёзын вакцинжуулалтад 416,0 мянган төл хамруулан 50,4 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.

“Улсын шилмэл мал 2019” гойд ашиг шимт малын үзэсгэлэн худалдаа Төв аймгийн Зуун мод хотод болж тус арга хэмжээний үеэр “Шилмэл мал”, “Айрагны баяр”, “Цагаан идээний” үзэсгэлэн зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулагдлаа. Манай аймгийн хувьд 4 сумын бог бод нийлсэн 19 толгой мал оролцож байгаагаас Хулд сумын хүрэн бор тэмээ, Өндөршил сумын шил адуу, Сайнцагаан хонь, Говь-угтаал сумын тулман хөхт ямаа зэрэг нь шалгаруулах номинацид оролцлоо. ХХААХҮЯ-наас 2019 оны батлагдсан төсөвт багтаан жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд лизингийн нөхцөлөөр тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг гүйцэтгэхээр сумдаас лизингийн нөхцөлөөр тоног төхөөрөмж авах саналтай байгаа иргэн, ААН-нэгжийн саналыг авч нэгтгэн ЖДҮХБХЗохицуулах газарт хүргүүлсэн.

Монголын хүнсчдийн холбооноос “Монгол улсын сүү бэлтгэлийн нөөц, улирлын хамаарал, сүү бэлтгэлд тулгамдаж буй бэрхшээлийг тодорхойлох” зорилго бүхий судалгааг 10 сумын 370 гаруй малчин өрхөөс авч хүргүүллээ.

ХХААХҮЯамнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Намрын ногоон өдрүүд арга хэмжээнд 3 сумын сүү цагаан идээ, даршилсан хөмүүлээр оролцох иргэдийн мэдээллийг хүргүүлсэн. Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн Сайдын тушаалаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хийх ажлын хэсэг газрын ажлыг шалгаж мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж яамны Өвөлжилтийн явц байдалтай танилцах ажлын хэсэг бэлтгэл ажилтай танилцлаа. Малчдын бэлтгэвэл зохих өвс, тэжээл, хадлан, гар тэжээл бэлтгэлийн мэдээг сумдаас авах ажил үргэлжилж байна.

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

“Хотод ойрхон говь” аялал жуулчлалын нэгдсэн эвентийн хүрээнд “Их говийн тэмээ-2019 арга хэмжээг Өлзийт сумын Цагаан суваргат, “Малчны баяр – 2019” арга хэмжээг Сайхан-Овоо сумын Онгийн голд, “Адуу, айрагны баяр-2019” арга хэмжээг Дэлгэрцогт сумын “Бага газрын чулуу” зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудад Аймгийн ЗДТГ, БОАЖГазар, Өлзийт, Сайхан-Овоо, Дэлгэрцогт, Адаацаг сумдын ЗДТГазар, “Говийн шуранхай” аялал жуулчлалын холбоо, жуулчны баазуудтай хамтран зохион байгуулж жуулчдад зориулсан Тэмээн уралдаан, морин бөмбөг, морь бугуйлдах, уурга шүүрэх, сур харвах, монгол гэрт зочлуулан, идээ ундаагаар дайлах үзүүлбэрүүд болон хуруу наадаан, дэмбээ, хэн сайн айраг уух вэ тэмцээнүүд, бөхийн барилдаан, даганы уралдаан зэрэг төрөл бүрийн уралдаан тэмцээнүүдийг Америк, Герман, Франц, Австри, Япон, Солонгос, Индонез, Ямайк зэрэг орны 250 орчим жуулчид болон дотоодын нийт 500 орчим аялагчид үзэж сонирхлоо.

Швейцарын хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төслийн газарт хамтран ажиллах гэрээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хүргүүлжээ. Дундговь-Түншлэл 2019 үзэсгэлэн худалдаа 9 дүгээр сарын 20-21-ны хооронд амжилттай зохион байгуулж 120 гаруй үйлдвэрлэгч оролцож 43,2 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. 9 сарын 20-ны өдөр Өлзий хутгийн наран ХХК-аар “Сумын төвийн хатуу хучилттай авто зам 2км (Эрдэнэдалай)”-ын ажлыг гүйцэтгүүлэхээр 1,505,395,150 төгрөгийн, Сайнцагаан сумын “Говийн ирээдүй цогцолбор сургуулийн спорт талбайн тохижилт”-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Мандал шилтгээн ХХК-тай 2019 оны 9 сарын 6-ны өдрийн 178,190,040 төгрөгийн, Санхүүгийн хяналт дотоод аудитын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх ажлын тендер шалгарсан Эй Кей Юу” ХХК-тай 9 сарын 20-ны өдөр 33,000,000 төгрөгийн, 9 сарын 20-ны өдөр Өлзий хутгийн наран ХХК-аар “Аймгийн төвийн 8,5 км авто замын нөхөөсийн засварын ажил”-ын ажлыг гүйцэтгүүлэхээр 184,587,867 төгрөгийн гэрээг тус тус байгууллаа.

Дулааны станцын шугамаар ирсэн “Энержи сервис мантаж” ХХК болон Солонгосын консрицумаас ирсэн хүмүүстэй уулзан станцын ТЭЗҮ орон нутагт нийцэж байгаа эсэхтэй зөвлөлдөж газар дээр нь үзлээ.

Төв суурин газрын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хэсэг 2019 оны 9-р сарын 25-ны өдөр аймгийн төвийн галлагааны 4 байгууллагаар ороход “Тэвшийн говь” ХХК: 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөндөө их засварын 3 ажил хийхээс 2 ажил 100% хийгдсэн. 2-р зуухны 4-р тогоог шинэчлэн солих ажил хийгдэж байна. Урсгал засварын 24 ажил хийгдэхээс 22 ажил 100% хийгдсэн. 2 ажлын хугацаа болоогүй. Нийт төлөвлөгөөний хэрэгжилт 98,4%-тай. Тэвшийн говь ХХК-аас сүлжээний усны зүй бус хэрэглээ, усны алдагдлыг бууруулах, дулааны горим ажиллагааны хэвийн найдвартай ажиллагааг хангах үүднээс 16, 18-3, 15, 63, 50, 57, 6, 74, 153, 9, 42-р байруудын иргэд болон Говь Ану, БӨХТ ХХК, Говийн гэгээ ХХК, Анд плаза, Жавхлан дэлгүүр, Цэн бум ХХК, Говийн ирээдүй цогцолбор сургууль, Алу ХХК, Алтан цант ХХК, Мэдээлэл холбоо сүлжээ, Малын удмын сангийн харьяа цөм сүргийн салбар, Хас банк, Анужин төв, Шорной дэлгүүр, Их жас равжих гэсэн 15 аж ахуйн нэгжүүдэд халаалтын шугамыг засварлах тухай мэдэгдэл хүргүүлсэн боловч хийгдээгүй тул халаалтаар хангахад хүндрэлтэй байгаа талаар ярьж 9-р сарын 30-ны өдөр өөрийн уурхайгаас нүүрсийг татан авахаар ажиллаж байна. “Ган-Илч” ХХК нь: 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөндөө 46 төрлийн засварын ажил хийгдэхээс 45 төрлийн ажил хийгдсэн. Систем задгайлах ажил хийгдэж байна. Нийт төлөвлөгөөний хэрэгжилт 97,8%-тай байна. “Энержи” ХХК-тай 1500тн нүүрсний гэрээ байгуулан 850тн нүүрс татан авсан байна. “Дундговь-Ус”: ОНӨҮГ: 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөндөө 11 төрлийн засварын ажлын хэрэгжилт 97,4%-тай байна. “Хангда” ХХК-тай 2000тн нүүрсний гэрээ байгуулан 140тн нүүрс татан авсан байна. Халаалтын ус шахах хугацаа: “Ган-Илч” ХХК, “Тэвшийн говь” ХХК, “Ариунболор” ХХК, “Үлэмж хурд” ХХК, “Ирмүүн түшиг” ХХК, “ОВЛ СКАЙ” ХХК, “Хангай илч дулаан” ХХК нар 2019 оны 9-р сарын 28-29-ны өдрүүдэд халаалтын шугамны ус шахахаар ажиллаж байна. “Дундговь-Ус” ОНӨҮГ 2019 оны 9-р сарын 21-ны өдөр халуун усны уурын зуухны халаалтын шугамны ус шахаж, 2019 оны 9-р сарын 23-ны өдөр конторын уурын зуухны шугамны ус шахсан байна.

БАЙГАЛЬ ОРЧИН: “Хоггүй цэвэрхэн Монгол” аян,Энгийн хог хаягдлын төлөвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг бууруулах зөвшөөрөл олгох журмыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хэлэлцүүлэг хийлээ. Сайхан-Овоо сумын Онгийн хийдэд “Нүүдэлчний баяр, Өлзийт сумын Цагаан суваргад “Их говийн тэмээ” аялал жуулчлалын эвент арга хэмжээг тус тус зохион байгууллаа. Гурвансайхан сумын нутагт хайгуулын тусгай зөвшөөрөлтэй “Аукумо майнз” ХХК-ний ус ашиглуулах дүгнэлтийг гаргалаа. Иргэн Т.Чингэлбаатарын Сайнцагаан сумын 9-р багийн цайны газрын үйлчилгээний төсөлд байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргалаа. Уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн нөхөн сэргээлтийн судалгааг БОАЖЯаманд хүргүүлжээ. Өндөршил суманд орших “Алтан хүрд проспектинг” ХХК, “Алтайн мандал майнинг” ХХК, “Мөнгөн пүрэв” ХХК, “Алт зэс проспектинг” ХХК, “Монголиа графит майнинг”, “Мөнх баялаг майнинг”, Дэлгэрхангай сумын нутагт орших “Алтан оргил ресорс” ХХК-ний байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тус тус хянан бүртгэлээ.

“Хоггүй цэвэрхэн Монгол” аян 1 жилийн турш Монгол орон даяар өрнөж байгаа бөгөөд “Хотод ойрхон говь” нэгдсэн эвент арга хэмжээний үеэр оролцогчид болон жуулчдад аяныг сурталчилж, Бага газрын чулуу байгалийн дурсгалт газрын хогийг түүж цэвэрлэлээ.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ойн зурвас байгуулах ажлыг аймгийн Засаг даргын А/302 захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Сайхан-Овоо сумын төв болон Бүрдийн уянга зуслангийн ойжуулалтын ажлыг хүлээн авсан. Сайхан-Овоо сумын төвийн ойжуулалтын ажлыг 95,5%-ийн амьдралттай, Адаацаг сумын нутаг дахь Бүрдийн уянга хүүхдийн зуслангийн ойжуулалтын ажлыг 75%-ийн амьдралттай хүлээж авав. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар. Экологийн боловсролыг дэмжих байгаль орчны англи хэл дээрх видео сургалт Байгаль орчин, аялал жуулчлалын газарт эхэллээ. Холбогдох хууль, тогтоомж биелүүлдэггүй, нөхөн сэргээлтийн ажлыг хангалтгүй хийж гүйцэтгэдэг ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн судалгаа, мэдээллийг БОАЖЯаманд хүргүүлжээ. Сайнцагаан сумын зочид угтах, үдэх хаалга болон Шаргын хөшөөны урд зам дагуу ангилан ялгах зориулалт бүхий 2 хогийн сав байршууллаа. Дэлгэрхангай сумын нутагт хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа “Мак цемент” ХХК, Өлзийт болон Сайнцагаан сумын нутагт хайгуулын үйл ажиллагаа явуулж буй “Юниверсаль логгинг” ХХК-ны ус ашиглуулах дүгнэлтийг тус тус гаргав.

ГХБХБГ: Баянжаргалан сумын 100 ортой цэцэрлэгийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллаж комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн. Луус сумын 80 ортой дотуур байрны барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт хийхэд 1 дүгээр давхрын гадна ханын өрлөгийн ажил хийгдэж ажлын явц 10 хувьтай. Дэлгэрхангай сумын 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт хийхэд гадна дотор заслын ажил хийгдэж ажлын явц 80 хувьтай. Эрдэнэдалай сумын 22 ортой сум дундын эмнэлэгийн барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт хийхэд гадна дотор заслын ажил хийгдэж ажлын явц 80 хувьтай.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газар болон Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран аймгийн төвийн олон нийт, үйлчилгээний барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй байдлын судлагааг хийж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа Гуяаны төгөлийг цэвэр усны нэгдсэн системд холбох ажлын явцад захиалагчийн хяналт хийхэд Трассын нүх ухаж, цэвэр усны шугамын угсралт хийгдэж ажлын явц 40 хувьтай.

2019 онд дуудлага худалдаагаар эзэмшүүлсэн 8 газрын байршлыг газар дээр нь тэмдэгжүүлжээ. Мөн ААН, иргэдийн захиалгын дагуу 21 газрын хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Газрын үнэ, үнэлгээ, татвар, төлбөрийн тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд нийт газар эзэмшигч, ашиглагчдын газрын төлбөрийн 2015-2019 оны судалгааг аймгийн хэмжээнд нэгтгэж Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газарт хүргүүлсэн.

Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх аргачлалын дагуу 15 сумын 212 цэгийн бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлтийг судлан sample point програмд 125 цэгийн мэдээллийг боловсруулаад байна. Сайнцагаан сумын 2019 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, зураг, тоон мэдээллийг Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газарт хүргүүлжээ.

ААН, иргэдийн захиалгын дагуу 15 газрын эргэлтийн цэгийг газарт бэхлэв. Дэлгэрхангай сумын төвийн гадна дулааны шугам сүлжээний ажлыг ашиглалтад оруулах комисс ажиллалаа.

Сайнцагаан суманд хувийн хөрөнгөөр баригдаж байгаа 5 орон сууцны барилгад захиалагчийн хяналт хийж гүйцэтгэсэн. Шинээр улсын төсвөөр баригдаж байгаа 150 ортой цэцэрлэгийн барилга, ахмадын өргөөний барилга, 2,8 км авто замын барилга мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа Гуяаны төгөлийг цэвэр усны нэгдсэн системд холбох ажилд тус тус захиалагчийн хяналт хийж гүйцэтгэсэн.

ГЗБГЗЗГ-аас зохион байгуулж буй 21 аймгийн мэргэжилтнүүдийн чадавхжуулах сургалтад тус байгууллагын 2 мэргэжилтэн хамрагдлаа. Сайнцагаан сумын 150 ортой 1

дүгээр цэцэрлэгийн барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэлээ. Зоорийн давхрын цутгалтын ажил дууссан. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй Гуяаны төгөлийг цэвэр усны нэгдсэн системд холбох ажилд захиалагчийн хяналт хийж гүйцэтгэсэн. Ажлын явц 90 хувьтай. ЦДҮС ТӨХК-ийн Говийн бүсийн салбарын оффиссын барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэлээ. Хүйтний улирал эхэлж байгаатай холбогдуулан барилга угсралтын ажил гүйцэтгэж буй аж ахуйн нэгжүүдэд зөвлөмж хүргүүллээ.

ОНӨГ: “Аймгийн төвийн Дулааны станцын 2-р хэлхээний шугам, сүлжээний зураг төсөв” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа. “Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны хэрэгцээнд автомашин” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт “Эй Кей юу” ХХК шалгарсан тухай үнэлгээний хорооны дүгнэлтийг захиалагчид хүргүүллээ. “Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2 км /Дундговь, Эрдэнэдалай сум/” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн шууд гэрээ байгуулах тухай үнэлгээний хорооны дүгнэлтийг захиалагчид хүргүүллээ. 9 дүгээр сарын 2-ны өдрийн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар доорх асуудлуудыг хэлэлцүүлж 3 болон 5 дугаар цэцэрлэгийн ирүүлсэн асуудал дэмжигдлээ.

Хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай /Баянжаргал сумын Эрүүл мэндийн төвийн хуучин барилга/, /Баянжаргалан сумын Хүүхдийн цэцэрлэгийн хуучин барилга/, Автомашинд үнэлгээ тогтоож, худалдах тухай /Хулд сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 64-16 ДУА улсын дугаартай УАЗ Патриот маркын автомашин/, Үндсэн хөрөнгө балансаас балансанд шилжүүлэх тухай /5-р цэцэрлэгийн цэвэр бохир усны шугамыг Дундговь-Ус ОНӨҮГт балансаас балансад шилжүүлэх/, /3-р цэцэрлэгийн цэвэр бохир усны шугамыг Дундговь-Ус ОНӨҮГт балансаас балансад шилжүүлэх/ тогтоолууд гарлаа.

“Аймгийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны” зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа. “Сайнцагаан сум, Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын тохижилт, ногоон байгууламжийн ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны дүгнэлтийг захиалагчид хүргүүллээ. Аймгийн төвийн орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, илүүдэлтэй ашиглагдахгүй хөрөнгөд хяналт шалгалт явуулах ажлын удирдамжийн дагуу нийт 26 байгууллагад үзлэг шалгалт хийхээс 8 байгууллагад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үзлэг хийх хугацааг хойшлуулж 18 байгууллагад төлөвлөгөөт хуваарийн дагуу үзлэг шалгалтын ажил хийгдлээ.

Аймгийн ЗДТГ-т эд хогшил нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг 9 сарын 19-ний өдөр нээлээ.

Монгол улсын Сангийн яам, Аймгийн Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газар хамтран 9 сарын 16-17-ны өдрүүдэд “Ерөнхий гэрээг зохион байгуулах нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж сургалтад сумдын засаг даргын орлогч, санхүү албаны дарга, аж ахуйн нэгж, худалдан авах ажиллагааны суурь гэрчилгээ эзэмшигч нарын төлөөлөл 100 иргэн оролцлоо. Мөн сургалтын үеэр Орон нутгийн өмчийн газраас 2019 оны 6 сарын 1-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээлэл өглөө. Аймгийн төвийн орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, илүүдэлтэй ашиглагдахгүй хөрөнгөд хяналт шалгалт явуулах ажлын удирдамжийн дагуу нийт 26 байгууллагад үзлэг шалгалт хийхээс 21 байгууллагад үзлэг шалгалт хийж зөрчил дутагдал илэрсэн байгууллагуудад зөвлөмж хүргүүллээ. Мандалговь хотын гэр хорооллын ус түгээх 14 худгуудыг смарт болгох тоног төхөөрөмж нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгох шалгаруулах тендерийг нээж үнэлж байна.

Адаацаг сум: Олон жил хамтын ажиллагаатай ажиллаж байгаа Сэлэнгэ аймгийн Жавхлант суманд ЗДТГ-ын хамт олон туршлага судлан 2 хоног ажиллав. Сумын ахмад настны баяр 2019.09.6,7-ны өдрүүдэд тэмдэглэн 73-н ахмад настан оролцож 8-н төрлийн тэмцээн уралдаан зохион байгууллаа. Мөн сум орон нутагтаа хийж бүтээсэн ажлыг үнэлж сумын засаг даргын “жуух бичиг”-ээр 4-р багийн ахмад настан Д.Чинбат, эх орны төлөө медалиар 3-р багийн ахмад настан Д.Элдэвт нарыг тус тус шагналаа. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр хөдөөгийн алслагдсан хүн амд эмнэлгийн анхан шатны цогц

тусламж үзүүлэх Mobile технологийн төслөөр хийгдэж багаа үзлэгт 4 бүлгийн 2-6 хүртэлх насны бүх хүүхдийг шинжилгээнээс бусад бүх үзлэгт хамруулав.

Баянжаргалан сум: Сангийн яамнаас зохион байгуулсан Худалдан авах ажиллагааны сургалтанд Засаг даргын орлогч, санхүүгийн албаны дарга, А-3 сертификаттай иргэд хамрагсан. Бүх нийтийн эрх зүйн боловсрол олгох сургалтыг аймгийн Хууль эрхзүйн хэлтэс, ГБХЗХХ-ээс зохион байгуулж сумын эрх зүйн хөтөч нартай гэрээ байгуулж, нийт 78 иргэн сургалтанд хамрагдаж, ганцаарчилсан зөвлөгөөг 15 иргэнд өгч ажиллаа. Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газраас 8 хүний бүрэлдэхүүнтэй баг ирж уул уурхайн компаниудын ажилчдад сүрьеэгийн илрүүлэг болон БЗДХ-ын тандалт судалгаа үзлэгийг зохион байгуулж 5 компанийн 130 иргэнийг хамруулан, цэрний сорьц 12-г авч нэгдсэн эмнэлэгт хүргээд байна. Мөн уушиг цээжийг рентген туяагаар гэрэлд харах шинжилгээг хийж тухай бүрд нь иргэдэд хариуг өгч ажиллаа. Хялгасан хорхойн шинжилгээг 95 хүүхдээс авч өвчлөл илэрсэн хүүхдүүдэд эмчилгээ зөвлөгөө өгч ажилласан. Аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эх барих эмэгтэйчүүдийн эмч болон өсвөр үеийн хүүхдийн эмч үзлэгт 26 эрэгтэй, 21 эмэгтэй хүүхдүүдэд хамрагдсан. Говь-сүмбэр ЦТС-д албан тоот хүргүүлж ЭМТ-н цахилгаанд үзлэг хийлгэн зөрчил илрүүлэн зөрлийг арилгах тухай албан тоот авч цахилгааны зөрлийг арилгах талаар хамтран ажиллаж байна. 2019-2020 оны хичээлийн шинэ жилд 14 багш, 171 сурагчтайгаар хичээл сургалтын үйл ажиллагаагаа жигдрүүлээд байна. Шинээр 6 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулах бүртгэл ажлыг зохион байгуулж өнөөдрийн байдлаар 20 сурагчийг хүлээн авлаа. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөнд тусгагдсан уурын зуухны 380-н цахилгааны мантожийг шинээр угсарч мантожлан хэвийн үйл ажиллагаанд орууллаа.

Дэлгэрхангай сум: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Тэлмэн нетворк” ХХК 28,900,000 төгрөгийн барилга, барилгын засвар, ухаалаг худгийн тоног төхөөрөмжийг 100% хийж гүйцэтгэн ашиглалтанд ороод байна. Санхүүгийн албаны төсөвт байгууллага болон төсөл сангуудын 255,4 сая төгрөгний 167 зарлагын гүйлгээ хийгдлээ. 2019.09.02-нд 2019-2020 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагааг 9:00 цагт албан ёсоор нээж 83 хүүхэд оролцож ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүд эцэг эх, ах эгч, дүү нартаа урлагийн номер үзүүлж бэлтгэл бүлгийн 35 хүүхдийг ЕББДС-д хүлээлгэн өглөө. 2019 оны 9-р сарын 13-14-ны өдрүүдэд Луус сумын цэцэрлэгийн хамт олон хүүхдийн цэцэрлэгийн гадна тохижилт, ногоон байгууламжыг үзэж туршлага судлан 2020 онд Луус сумын цэцэрлэгийн хамт олонд ногоон орчин бүрдүүлэхэд нь тусалж дэмжин хамтарч ажиллахаар болов. 2019-2020 оны Хичээлийн шинэ жилийн нээлтээр хурдан дааганы уралдаан, 3 насны ангиллаар бөхийн барилдаан зохион байгуулагдлаа. Энэ хичээлийн жилд нэгдүгээр ангид 42 сурагч элсэн орж, залуу боловсон хүчин 5 –аар нэмэгдлээ. 2019-2020 оны хичээлийн жилд 440 суралцагч, 62 багш ажилтантайгаар сургалт хүмүүжлийн ажил явагдаж байна. Нээлтэнд зориулсан хурдан дааганы уралдааныг Дэлгэрхангай сумын уугуул “Эмнэг сургалтын спортын мастер” Дашдооровын Эрдэнэбат ивээн тэтгэж даага унаж уралдсан бүх хүүхдүүдэд гарын бэлэг өгч амжилттай зохион байгууллаа.

"Шинэ Монгол" бүрэн дунд сургууль, Төрийн шагналт, Ардын уран зохиолч С.Дашдооровын нэрэмжит, Дэлгэрхангай сумын ЕББДС-тай хамтран жил бүр зохион байгуулдаг "ГОВЬ АЯЛАЛ" уламжлал ёсоор болж өнгөрлөө. Энэ удаагийн хөтөлбөрийн онцлог нь "Адуучин" өдөрлөг зохион байгуулсан нь "Шинэ Монгол" Бүрэн Дунд сургуулийн сурагчдад малчин ахуй өв соёл, адууны соёлыг харуулсан сонирхолтой үйл ажиллагаа болсон билээ.

Уг өдөрлөгөөр эмнэг сургалт, уурга шүүрэх, морь уургалах зэрэг үзүүлбэр, хуруу гарган айраг уух, мөн сурагчид зуны амралтаар өөрийн хийсэн цагаан идээгээр үзэсгэлэн гаргасан болно.

Сохор доголын вакциныг 3000 ямаа, сахуугийн вакциныг 250 унага, бруцеллёзын вакциныг эхлээд ШТС-19 тугал 58, рев-1 вакцин хурга 8000, ишиг 10800 тус тус дархлаажуулалтын вакцины ажил хийгдэж байна

Дэлгэрцогт сум: ЗЗББУХ төслийн санхүүжилтээр Цахиурт, Баянбулаг багуудад бог мал угаалгын банн барих ажлыг "Таанынамт" ХХК гүйцэтгэж, 2019 оны 9 сарын 5-нд сумын Засаг даргын захирамжаар томилогдсон комисс ашиглалтанд хүлээн авлаа. "Адуучин, айрагны баяр-2019" бэсрэг наадмын нээлтийн үйл ажиллагаа амжилттай зохион байгуулагдлаа. "Адуучин, айрагны баяр-2019"-ийн багаар хуруудах тэмцээнд Б.Эрдэнэцэцэг ахлагчтай залуусын "Золбоо" баг тэргүүн байр, Г.Гармаадорж ахлагчтай ахмадуудын баг 3-р байр, эмэгтэйчүүдийн дэмбээ наадамд ахмад настан Д.Цэцэгбалам 1-р, Л.Маадорж 3-р байр, "Айраг хэн сайн уух вэ" тэмцээнд Дэлгэр-Эмт багийн Т.Уугандалай, Н.Наранцэцэг нар

тэргүүлээ. Хүн ам, орон сууцны тооллогын комиссыг байгуулан, тооллогын комиссын дарга, нарийн бичгийн дарга, тоологч нар аймгийн ЗДТГ-т 2 өдрийн сургалтанд хамрагдлаа. ОНХС-ийн туршлага судлах ажлаар сумын Засаг даргын орлогч Өвөрхангай аймагт ажиллаж байна.

Өлзийт сум: Аймгийн 2019 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг гаргаж ХОХБТХ, Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлээ. Алслагдсан сумдыг шилэн кабелийн сүлжээнд холбохоор 2019.08.05-ны өдрөөс эхлэн тус сумын шилэн кабелийн суурилуулалтын ажлыг Монкабель системс ХХК гүйцэтгэж одоогоор газар шорооны ажил дуусаад байна. Харилцаа холбоо, мэдээлэл, технологийн газрын инженер хамтран ажиллах гэрээний дагуу ажлын гүйцэтгэлийн явцад мэргэжлийн хяналт шалгалтыг газар дээр нь тогтмол хийн ажиллаж байна. Хөдөө аж ахуйн салбар болон төв, суурийн газрын 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар Засгийн газрын 2019 оны 270, 285 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр Албан даалгавар, 2019 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/282 дугаартай захирамжийг хэрэгжүүлэн сумын Засаг даргын 2019 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн А/129 дүгээр захирамжаар сумын ХАА-н салбарын 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хэсгийн захирамжийг, төлөвлөгөөг Аймгийн ТЗУХ, ХОХБТХ-т хүргүүлж, мөн сумын комиссын гишүүдэд хүргүүлэн өвөлжилтийн бэлтгэл хангаж ажиллах үүргийг өгөөд байна. Сумын 2019 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэхээр батлагдсан Буянтын 1, 2-р багийн Соёлын төвийн барилгын их засварын 147,555,915 төгрөгийн ажлын гүйцэтгэгчээр “Түшиг мандал” ХХК тендер шалгарч гэрээ хийж барилгын засварын ажлыг 100% гүйцэтгэж комисс газар дээр очиж ажиллан хүлээж авлаа. Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсээс улсын хэмжээнд зохион байгуулж байгаа “Эко-2019” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн цагдаагийн газраас Өлзийт суманд жоншны нөхөрлөлд бүртгэлтэй, бүртгэлгүй иргэдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиар сургалт зохион байгууллаа. “ХОТОД ОЙРХОН ГОВЬ”, “ИХ ГОВИЙН ТЭМЭЭ-2019” эвент нэгдсэн арга хэмжээг 2019 оны 9 дүгээр сарын 7, 8-ны өдрүүдэд сумын байгалийн үзэсгэлэнт газар болох Цагаан суваргат зохион байгуулж нутгийн малчид, ингэний брэнд бүтээгдэхүүнээ худалдан борлуулж орон нутгаа сурталчилж амжилттай оролцлоо. Тус арга хэмжээг Хүнс, хөдөө аж ахуйн газар, “Говийн шуранхай” аялал жуулчлалын холбоо, Өлзийт сумын Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгууллаа. Тэмээний баярын үеэр Аймгийн тэмээний алдарт уяачийн журмын болзолыг хангасан 3-р багийн малчин Д.Энхбат “Аймгийн алдарт тэмээний уяач” цол тэмдгээр шагнагдлаа. Ат, торомны уралдаан, ганган хос шалгаруулах, буйл зорох, бурантаг томох уралдаан тэмцээнүүд боллоо.

Дорнод аймгийн Хэрлэн суманд зохион байгуулж буй Уул уурхайн салбарын бодлого хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх зөвлөгөөн, хэлэлцүүлэгт Засаг даргын орлогч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч нар оролцож байна. Сангийн яамнаас зохион байгуулсан “Ерөнхий журмаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах” сэдэвт сургалтад Засаг даргын орлогч, ЗДТГазрын дарга, Санхүүгийн албаны дарга, Аж ахуй нэгжийн төлөөллөөс “ДДБГА” ХХК-ний захирал нар хамрагдаж мэдээлэл авлаа. Буянт багийн Соёлын төвийн барилгын нээлтийн үеэр “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулахаар төлөвлөж, төрийн ажил үйлчилгээг малчдад хүргэж ажиллахаар хөтөлбөрийг боловсруулаад байна. Дундговь түншлэл-2019” үзэсгэлэн худалдаанд сум хөгжүүлэх сангаас зээл авч түр ажлын байраар хангагдсан иргэдэд зар мэдээллийг хүргэж үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийг дэмжин сурталчилан оролцож байна.

Сайнцагаан сум: Байгууллагын албан хаагчид МУ-ын ерөнхий сайдын ивээл дор хэрэгжиж буй “Хайртай” аяны зохион байгуулагчдыг угтах үйл ажиллагаанд оролцлоо. Уг аяны “Эрчүүдийн ноён нуруу” сэдэвт уулзалтад иргэд болон байгууллагын эрчүүдийг оролцууллаа. Айраг, Мандал багийн хаягжуулалтын ажил бүрэн дуусч хүлээн авлаа. Багийн Засаг дарга нар, Хот тохижуулах газрын дарга, инженерүүд “Хоггүй цэвэрхэн Монгол аян”-ны хүрээнд Байгаль орчны газраас зохион байгуулж буй “Эрүүл цэвэр хот” хэлэлцүүлэгт оролцлоо.

Боржигон баг Сумын ГХУСАЗЗ-тэй хамтран багийн камерын хяналттай 3 бүсэд камер таних тэмдэг, 7 цэгт хөршийн хяналтын бүс самбарыг байршууллаа. Сумын өвөлжилт, хаваржилтын бэлэн байдлын төлөвлөгөө гарган харъяа байгууллагад хүргүүлээ. Зориулалтын бус саванд цагаан идээ зарахыг хориглосон тухай Сумын засаг даргын 2019.09.04-ний А/194 тоот захирамж гаргалаа. Сумын ЗДТГазрын үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг Засаг даргад хянуулан батлууллаа. Сумын “Эрх зүйн хөтөч”-өөр бэлтгэгдсэн 5 албан хаагчидтай гэрээ байгуулан ажлын төлөвлөгөө гаргалаа.

Хулд сум: “Дундговь түншлэл -2019” арга хэмжээнд малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд нийт 7 хүн өөрсдийн хийсэн сүү цагаан идээ, жижиг үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр оролцож байна. Өвөрхангай аймагт зохион байгуулж буй ОНХС-ын сургалт, Дорнод аймагт зохион байгуулагдаж байгаа Уул уурхайн өдөрлөг арга хэмжээ, Дундговь аймагт зохиож байгаа хүн ам, орон сууцны тооллогын семинаруудад холбогдох ажилтнууд оролцож байна. Намрын цэрэг татлагатай холбоотойгоор цэргийн насны залуучуудын судалгааг гарган цэрэг татлагад хамрагдах залуучуудад зарлан дуудах хуудас хүргэж цэрэг татлагын бэлтгэл ажил хангаж байна. НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрт шалгарсан сумын ОНХС-ын хяналтыг сайжруулах чиглэлээр суманд зохион байгуулсан 1 хоногийн сургалтанд ЗДТГ-ын ажилтнуудыг хамруулж 40 гаруй оролцогчид 2016-2019 оны ОНХС-ын хэрэгжилт дүгнэлтийн талаар илтгэл танилцуулга хийв. Аймгийн Засаг даргатай байгуулсан 2019 оны үр дүнгийн гэрээний хагас жилийн биелэлтийг тооцон аймагт хүргүүлэв. Аймагт зохиогдсон ХАБЭАхуйн 2 өдрийн сургалтанд байгууллагуудын ХАБЭА хариуцсан 6 ажилтныг хамруулан сертификаджуулав.

Цагаандэлгэр сум: Сумын засаг даргын Тамгын газрын зүгээс ард иргэдэд төрийн үйлчилгээг зохих хууль дүрмийн дагуу үзүүлж ирлээ. ЗДТГ-ын аппарат 7 хоног бүрийн 1 дэх өдрүүдэд шуурхай цуглааныг хийж өнгөрсөн 7 хоногт хийгдсэн ажлын биелэлт, гарч буй 7 хоногт хийгдэх ажлуудын талаар мэдээллийг хэлэлцэж ирлээ. Мөн албан байгууллагын дарга, эрхлэгч нарын хурлыг 7 хоног бүрийн 5 дах өдөр хийж байгууллага дээрээ хийсэн ажлын биелэлт, дараа 7 хоногт хийх ажлын талаар мэдээллийг хэлэлцэж байна.

ӨНДӨРШИЛ СУМ: Намрын хяналтын ажлыг амжилттай зохион байгуулж, ХХААХҮЯ-ны сайдын зөвлөлийн хурлаар оруулахаар боллоо. ХХААХҮЯ-ны МААЗБГ-н МГНТХ-ийн дарга, МУ-ын ерөнхий мал зүйч, Ажлын хэсгийн ахлагч докторант Д. Батсүрэн, Нарийн бичгийн даргаар ХХААХҮЯ-ны МААЗБГ-ын МГНТХ-ийн ахлах мэргэжилтэн Ц. Түмэнбаяр. Гишүүдэд МУ-гавьяат малзүйч, МУ-ын зөвлөх мал зүйч, Адуу судлаач Д. Самданжамц, ХААИС-ийн их эрдмийн зөвлөлийн гишүүн МУ-н зөвлөх мал зүйч, ХААУ-ны доктор Адуу судлаач Т. Сайполда, МХГ-н ахлах байцаагч МУ-ын зөвлөх мал зүйч, ХААУ-ны доктор Д. Батмөнх, МЭАЦТЛ-ийн эрдэм шинжилгээний ажилтан ХААУ-ны доктор А. Саруулжаргал, ХААИС-ийн багш доктрант Ц. Мөнгөнцэцэг нар ажиллаа. Дундговь аймгийн минь түүхэнд анх удаа ШУ-ны үндэслэлтэй баталгаажсан омгийн малтай болох боломж бүрдэж байна.

Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, их эмч Д. Эрдэнэчулуунтай хамтран ажиллах гэрээ байгуулж, сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж нийт 45 хүүхэд, амны хөндийн өвчлөлийг илрүүлэх үзлэг зохион байгуулав ЕБС-ийн 6-12 насны 164 сурагчид хамрагдаж шүдний өвчлөлийг тогтоож, амны хөндийн өвчинөөс урьдчилан сэргийлэх талаар сурталчилгаа хийв.

Хог хаягдлын менежментийг сайжруулах, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр Хортон шавж устгах ажлыг байгууллагтаа “Сайн түшиг” ХК-иар хийж гүйцэтгэв. Хичээлийн шинэ жилийн үйл ажиллагаа маан өргөн дэлгэр сайхан болж, 1-р ангид 29 сурагч элсэн орж, нээлтэд зориулсан даганы уралдаан болж, хүүхдийн дунд цоллооч хүүхэд, гийнгоо марзий, тус бүр 1 хүүхэд шалгаруулан шагнаж урамшууллаа. Багш нар маань Гурвансайхан суманд “хүүхэд бүрт хүрч ажиллах” зорилготой сургалтанд Нийт 7 багш хамрагдаж 2 өдрийн сургалтанд суралцаад ирлээ. Иргэдийн төлөөлөгчийн хурлаас 1-р багийн нутагт Эм Ди Эф компаний байгуулж байгаа баяжуулах үйлдвэрийн талаар иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулж байгаа шилмэл малын үзэсгэлэн худалдаанд нутгийн бахархал Өндөршилийн адуугаа сурталчилан танилцуулан оролцож байна.

Смарт худгийн тендерийг зарлалаа. 9 сарын 5-нд Эрүүл мэндийн төвийн их эмч Д.Эрдэнэчулуун байгууллагын багш, ажилчдад “Антибиотикийг эмчийн жороор” сургалтыг

зохион байгуулж, витаминжууллаа. Цэцэрлэгийн хүүхдүүдийг чийрэгжүүлэх, дархлааг сайжруулах зорилгоор "Шар сүү, айргаар" иллэг хэрхэн хийх талаар, эрүүл мэндийн төвийн их эмч Д. Эрдэнэчулуун туслах багш нарт зөвлөгөө өгч, БАГА бүлгийн хүүхдүүдэд биечлэн хийж үзүүлээ. 9 сарын 9-нд Ургамал дэд сэдвийн хүрээнд "Цэцгийн баяр" хийж, "ЦЭЦЭГ БҮХЭН САЙХАН" сэдэвт бүлгийн хүүхдүүдийн болон багш, ажилчдын тарьж ургуулсан цэцгээр үзэсгэлэн гаргалаа. Бага дунд ангийн дунд зохион байгуулагдсан "Алтан намар сфиртакад" амжилттай болж өндөрлөлөө.

Эрдэнэдалай сум: Цагаан овоо багийн нутаг дэвсгэрт хайгуул хийж байгаа тухай иргэдээс ирсэн мэдээллийн дагуу Засаг даргын орлогч Ц.Бадамцэрэн, 5-р багийн Засаг дарга Б.Сумъяадорж, Байгаль орчны улсын байцаагч Д.Батбаяр, Цагдаагийн хэлтсийн цагдаа нар "Гео-Эрин" ХХК-ийн төлөөлөлтэй уулзаж ажлын явцтай танилцлаа. Уг компани нь Эрдэнэдалай, Адаацаг, Луус, Дэлгэрхангай сумын нутагт Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны захиалгаар ашигт малтмалын эрэл хайгуулын ажил хийж гүйцэтгэж байгаа бөгөөд хээрийн судалгааны ажил нь энэ оны 10 дугаар сард дуусах юм байна. Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 35 дугаар тогтоолоор батлагдсан тус сумын нутаг дэвсгэрт мөрдөх энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифийг баталлаа. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн санхүүжилтээр тус сумын 3-р багийн нутаг "Мөргүй", 6-р багийн нутаг "Гэр чулуун" хэмээх газруудад мал угаалгын ванныг "Тааны амт" ХХК барьж гүйцэтгэлээ. Уг ажлыг 2019.09.05-ны өдөр Сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан комисс хүлээн авлаа. Сар бүр уламжлал болгон зохион байгуулагддаг ахмадын дуулах цэнгүүнийг энэ сарын 15-ны өдөр Ахмадын хороо, Цагдаагийн хэсэг, Төрийн банк хамтран зохион байгуулаа. Цэнгүүнд 70 гаруй ахмад оролцож, дуулж бүжиглэн хөгжөөнтэй тэмцээн уралдаанд оролцлоо. Цэнгүүнд Дундговь аймгийн ахмадын хорооны дарга Ц.Сугар, тэргүүлэгчид С.Бямбасүрэн, Т.Чимэдцэеэ, нягтлан Наранчимэг нар оролцож 2018 онд хийсэн ажлын тайланг тавьж, Эрүүл хооллолтын талаар сургалт зохион байгуулсан. Мөн сумын ахмадын хорооны тэргүүлэгч Ц.Ичинноров Монголын ахмадын холбооны хүндэт тэмдгээр, ахмад настан Ч.Ядамдорж, З.Дэжидмаа нар Дундговь аймгийн ахмадын хорооны хүндэт өргөмжлөлөөр шагнагдсаныг гардуулан өглөө. Айрагны баяр-2019 арга хэмжээ: энэ сарын 18-ны өдөр болж дэмбээний тэмцээн, хэн хамгийн их айраг уух вэ?, хуруу барих, морин дээрээс малгай булаалдах зэрэг тэмцээн уралдаан зохиогдсон бол үзэсгэлэнд шилдэг сүү сүүн бүтээгдэхүүн, шилдэг суран эдлэл, модон эдлэл, шилдэг гар урлал, үндэсний хувцас, өндөр шимт хээлтүүлэгч, шилдэг хүнсний ногоо тариалагч, шилдэг айрагтай өрх зэрэг номинацаар шилдгүүдээ шалгаруулсан байна. Нийт 28 оролцогч бүтээлээ дэлгэн сонирхууллаа. Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу "АЛТАН НАМАР" спартакиадыг "ЭРҮҮЛ ХӨДӨЛГӨӨН-ЭМ" уриан дор Бүрэн дунд сургууль, Байгалийн ухааны заах аргын нэгдэл хамтран зохион байгууллаа. Уг үйл ажиллагаанд ЕБС, ЗДТГ, Цэцэрлэг, Хүн эмнэлэг, Спорт зал, Цагдаагийн хамтарсан баг, Хаан банк, Төрийн банк, Гялс төвийн хамтарсан баг, Онцгой байдлын алба зэрэг байгууллагын 70 гаруй тамирчид спортын 7 төрөлд хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө. "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус суманд хууль тогтоомж сурталчлах өдөрлөгийг Оюуны гэгээ ТББ болон хууль хяналтын байгууллагуудтай хамтран зохион байгуулав. Тус өдөрлөгт иргэд, төрийн байгууллагын 100 гаруй алба хаагчид оролцож мэдээ, мэдээлэл авахаас гадна шүүх, хуулийн байгууллагын мэргэжилтнүүдтэй ганцаарчилсан уулзалт хийж хуулийн зөвлөгөө, мэдээлэл авсан байна. Өдөрлөгт идэвхтэй оролцсон иргэдийн дунд хуулийн АХА тэмцээн зохион байгууллаа. 2019-2020 оны хичээлийн жилд цэцэрлэгт хамрагдах хүүхдийг бүртгэн авч 10 бүлгийн 329 хүүхдийн судалгаа мөн багш ажилчдын судалгаа, хувилбарт сургалтанд хамрагдах 94 хүүхдийн мэдээллийг шивж оруулан ESIS.EDU.MN программд 9 сарын 15-нд хугацаандаа илгээлээ. Анги бүлэг бүр хүүхдийн дэлгэрэнгүй судалгааг гаргахад цэцэрлэгийн хэмжээнд 329 хүүхэд бүртгэгдэж үүнээс эрэгтэй 181 эмэгтэй 148 хүүхэд байна. Шинээр элссэн хүүхэд 128, малчин өрхийн хүүхэд 215, хагас өнчин 5 хүүхэд гадны харъяалалтай 8 хүүхэд байна. Цэцэрлэгийн 11 багш Дундговь аймагт

“Сайжруулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй “сургалтанд хамрагдаж ирээд сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан хичээл сургалт үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Цэцэрлэгийн хүүхдийн эмч Б.Оюун Дундговь аймагт “Эрүүл насжилт настны эрүүл мэнд “үндэсний хөтөлбөр “Эрүүл иргэнтэй Дундговь” хөтөлбөрийн хүрээнд 2 хоногийн сургалтанд хамрагдаж ирээд ажилчдад “Хөдөлгөөн эрүүл мэнд “дасгал зааж эхлэж байна.

Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд анги коридорын 12 шар гэрэл, 4 хөх гэрэл шатсан 6 ширхэг разеткийг шинээр авч янзаллаа. Цэцэрлэгийн гадна гэрэлтүүлэг шатсаныг шинээр сольж байрлууллаа. Багш ажилчид 1 шуудай адууны хомоол, 2 хүн дундаа 1 шуудай таана өвс түүж нөөцлөх ажил 50% тай байна.

2019 оны 9 дүгээр сарын байдлаар 877 хүнд урьдчилан сэргийлэх үзлэг хийгдэж өвчний учир амбулаторт 199, Өвчний учир анх 130, давтан 69, диспансерийн идэвхитэй хяналт 250, гэрийн дуудлага 30, гэрийн идэвхитэй эргэлт 79, урьдчилан сэргийлэх үзлэг 319 хийгдсэн байна. Нас баралт 2, төрөлт 5, хөх, умайн хүзүүний эрт илрүүлэг шинжилгээнд 71, артерийн гипертензийн эрт илрүүлэг 62, чихрийн шинжингийн эрт илрүүлэг үзлэгт 69 хүнийг хамруулсан байна. Түргэн тусламжийн 92 дуудлаганд үйлчилсэн байна. Түргэн тусламжийн дуудлага өмнөх сарынхаас нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Жил бүрийн 9-р сарын 10-ны өдөр Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан сурагчдын эх түүхийн талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэдний оролцоог дэмжих, асуудлыг олон талаас нь харж шийдвэр гаргах чадварыг эзэмшүүлэх зорилгоор тус сургуулийн захиргаа болон Түүх-нийгмийн ухааны заах аргын нэгдэл хамтран 8-9-р ангийн сурагчдын дунд хэлмэгдүүлэлтийн сэдэвтэй ханын сонины уралдаан, 10-12-р ангийн сурагчдын дунд “Дэвжээ” тэмцээнийг амжилттайгаар зохион байгууллаа. Уг тэмцээн нь түүх-нийгмийн ухааны заах аргын нэгдлийн хичээлийн шинэ жилийн сургалт хүмүүжил, хүүхэд хөгжлийн үйл ажиллагааны нээлт болсноороо онцлогтой юм. 2019 оны ГЗБ-төлөвлөгөөний дагуу Дэнжийн сууцны урд талд 150 м кв газрыг үйлдвэр үйлчилгээний зориулалтаар, Нийтийн ахуй үйлчилгээ болон шинэ хүн эмнэлгийн баруун талд 300 м кв газрыг худалдаа бүх төрлийн үйлчилгээний зориулалтаар тус дуудлага худалдааг цахимаар зарлаад байна. Тус сумын 2019 оны бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлын хүрээнд хөдөөгийн 6 багийн нийт 24 цэгт хээрийн судалгаа хийж, уг ажлыг Sample point праграмм дээр боловсруулж үр дүнг газрын удирдлагын “Web” системд шивж оруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Мэргэжлийн хяналтын байгууллагын 2019 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 01/164 тоот удирдамжийн хүрээнд ерөнхий газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Б.Баясгалан, аймгийн мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Э.Бямбасүрэн нар сумын ундны усны чанар, аюулгүй байдал хийсэн хяналт шалгалтын хүрээнд өгсөн албан шаардлагын дагуу Сургууль, Цэцэрлэг, Сод бриллианд ХХК, Монхарбор сувилал, ЗДТГ-ын мэдэлд байдаг худгуудтай холбоотой зөрчил дутагдлыг арилгах талаар хийгдсэн ажлын тайлан мэдээг хүргүүлсэн болно. ИТХ-ын 2019 оны 06-р сарын 06-ны өдрийн А/35 тоот тогтоолын дагуу иргэн аж ахуй нэгж албан байгууллагын хог хаягдлын төлбөр хураамжийг бүрдүүлэх ажлыг эхлүүлэн Сумын засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн тоотын дагуу ЕБС, Эмнэлэг, Сувилал, ЗДТГазар Цэцэрлэг, Соёлын төв зэрэг газруудад нэхэмлэх өгч төлбөрийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн иргэдэд мэдээлэл өгөх зорилгоор уг тогтоолыг сумын facebook хаягт байршуулав. Хогийн нэгдсэн цэгт ланdfилл байгуулах ажлын тооцоо судалгааг гаргаж тендэр зарлахад бэлэн болгоод байна.

